



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 ны 07 сарын 21 өдөр

Дугаар Д/407

Хэрлэн сум

“Colorful” дуу хөгжмийн фестивальд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.2, 12.4 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ:

1. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2.4.11.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор залууст зориулан “Colorful” дуу хөгжмийн фестивалийг 2023 оны 7 дугаар сарын 29-д зохион байгуулах зардалд 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг “Залуучуудын оролцоотой сайн дурын үйл ажиллагааг 50 хувиар нэмэгдүүлэх” зардалаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Х.Уртнасан)-д, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ